

**“МОНГОЛ СЕКЮРИТИЕС ҮЦК” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2024 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 05 дүгээр сарын 23-ны өдрийн 10.00 цагт Улаанбаатар хот Хан-уул дүүрэг 15 хороо, Гэгээнтэн цогцолбор 215 тоотод болов.

Хуралд :

- З.Номундарь 300,922 ширхэг хувьцааны саналаар буюу нийт гаргасан хувьцааны 1% /өөрийн биеэр/
- Л.Гүндэгмаа 75,800 ширхэг хувьцааны санал буюу нийт гаргасан хувьцааны 0.25% /өөрийн биеэр/
- Коуанаги Юдиро 28,499,975 ширхэг хувьцааны санал буюу нийт гаргасан хувьцааны 95 % /итгэмжлэгдсэн төлөөлөгч Карагүчи цахимаар/

Нийт **28,876,697** ширхэг хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 96.3 хувийг эзэмшигчид болон Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд болох З.Номундарь, Л.Гүндэгмаа, А.Баатаржав, Б.Баярсайхан болон тооллогын комиссын дарга Л.Гүндэгмаа, комиссын гишүүд М.Нэргүй, Б.Мөнгэрэл нар оролцов.

Хурлыг Л.Гүндэгмаа удирдав.

Хурлын дэг болон хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг уншиж танилцав.

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэхээр танилцуулав.

- Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат гишүүнийг дэвшүүлэх, томилох
- Дүрмийн санг нэмэгдүүлэх, зохистой харьцааны үзүүлэлтийг хангах ажиллах талаарх танилцуулга, төлөвлөгөө
- Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
- Бизнес төлөвлөгөө
- 2023 оны санхүүгийн тайлан

Хурлын дарга: Тооллогын комисс ирцээ гаргасан бол танилцуулья.

Тооллогын комиссын гишүүн М.Нэргүй ирцийг танилцуулан, Тооллогын комиссын анхны тогтоолыг уншиж танилцуулав. Тооллогын тогтоолоос үзэхэд хурлын ирц 96.3% байгаа тул Монгол улсын компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу хурлын ирц бүрдэж байна.

3.Номундарь: Энэ жилийн хувьд мөн л компанийн гол хувьцаа эзэмшигч маань өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан цахимаар хуралд оролцож байна. Олон жилийн дараа хувьцаа эзэмшигчдийн маань хурал ирцэндээ хүрч хуралаараа компанийн цаашдын үйл ажиллагаагаа сайжруулах шийдвэрүүд гарна гэдэгт итгэлтэй байна. Хурлаар хэлэлцэх асуудлын дагуу эхний ээлжинд компанийн санхүүгийн одоогийн нөхцөл байдлын талаар хэлэлцээд дараа нь ТУЗ-н гишүүдийг томилох асуудал дараа нь бизнес төлөвлөгөөг хэлэлцье.

Карагүчи: Ноён Коёанаги өвчний улмаас энэ олон жил компанийн үйл ажиллагаанд оролцох боломжгүй байсан юм. Энэ удаад мөн өөрийн биеэр оролцох боломжгүй байгаа тул миний бие Карагүчи-г итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилон хуралд оролцуулж байна. Хурлаар хэлэлцэх асуудлуудаас Санхүүгийг тайланг баталгаажуулах асуудлыг хэлэлцээд бусад асуудлуудыг хэлэлцэхээс ноён Коёонаги татгалзсан болно. Иймд 2023 оны санхүүгийн тайланг хэлэлцэж баталаад энэ удаагийн хурлыг дуусгая.

3.Номундарь: За ойлголоо. Ямарч байсан хуралаараа санхүүгийг тайлангаа батлая.

М.Нэргүй: “Монгол Секьюритиес ҮЦК” ХК нь 2023 онд 500,345.66 төгрөгийн борлуулалт хийж, 56,540,201.31 төгрөгийн зардал гаргаж 56,039,845.65 төгрөгийн алдагдалтай ажилласан. Санхүүгийн үр дүнгийн хувьд 2023 онд нийт хөрөнгө 1,050,378,829.19 төгрөг үүнээс эргэлтийн бус хөрөнгийг 3,320,897.78 төгрөг, эргэлтийн хөрөнгө 1,047,057,931.21 төгрөг, өр төлбөр 284,457,252.40 төгрөг, эздийн өмчийн дүн 765,921,576.79 төгрөг байна.

Хурал 11 цаг 00 минутанд өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН



/М.НЭРГҮЙ /